



Implemented by:



In cooperation with:



MINISTRY OF ENVIRONMENT,
GREEN DEVELOPMENT
AND TOURISM



Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын 2017 оны ажлын тайлан



**Монголын Ойн Тогтвортой Менежментийн Зөвлөл ТББ-ын 2017 оны жилийн
эцсийн тайлан**

Хөтөлбөрийн нэр	Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II
Зорилт	Ойн магадлан итгэмжлэлийн тогтолцоо бий болгох
Монголын Ойн Тогтвортой Менежментийн Зөвлөл төрийн бус байгууллагын хаяг	Чингэлтэй дүүрэг, IV хороо, Самбуугийн гудамж 13/2 Глобал бизнэс төв 403 тоот Хариуцагч: Д.Мөнхзориг Имайл: munkhzorig@forest.mn; Утас: 70009501, 88119501
Тайлангийн хугацаа	4-р сараас 12 сар (2017)

Гүйцэтгэлийн Хураангуй

“Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” төрийн бус байгууллагын гол зорилго нь Монгол улсад ойн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд оршино. Ойн тогтвортой менежмент нь эдийн засаг, экологи, нийгмийн тогтвортой хөгжил гэсэн үндсэн гурван зарчим дээр суурилсан байдаг бөгөөд эдгээр үндсэн зарчмуудад тулгуурлан Монголын ойн магадлан итгэмжлэлийн тогтолцоог бий болгож, ойн гаралтай бүтээгдэхүүн болон дагалт бүтээгдэхүүний чанарыг сайжруулах явдал юм. ХБНГУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II” хөтөлбөр нь Үндэсний магадлан итгэмжлэлийн загварыг бий болгох, санал санаачлагыг дэмжин ажиллаж байна. “Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ нь 2017 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Чадварлаг шинжээчдийг бэлтгэх зорилгоор МОТМЗ нь 10 сард Улаанбаатар хотод шинжээчдийн сургалт зохион байгуулж 12 мэргэжилтэнд шинжээчийн батламж олгов.
- Нийт 7 ойн мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмжлэлд хамруулсны дээр өмнөх жилийн итгэмжлэгдсэн 4 ойн мэргэжлийн байгууллагуудын ахиц дэвшлийн тайланг хүлээн авч зөвлөгөө өгч ажиллав.
- Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн БОАЖГ, сумдын удирдлагуудтай хамтарсан гэрээ байгуулж ААН-үүд өөрийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх боломж бий болгох арга хэмжээ авав.
- Ойн магадлан итгэмжлэлийг олон нийтэд сурталчлах зорилгоор www.forest.mn цахим хуудсыг бий болгож, мэдээ мэдээлэл тогтмол оруулан ажиллуулж байна.
- Ойн магадлан итгэмжлэлийн зорилго, үр ашгийг сурталчилсан богино хэмжээний кино хийж олон нийтийн телевизээр гаргасан.
- Ойн тогтвортой менежмент, магадлан итгэмжлэлийн талаар 3 аймагт сургалт семинар зохион байгуулав.
- Ойн магадлан итгэмжлэл, түүнтэй холбоотой асуудлуудаар Монголын өдөр тутмын сонин “Өнөөдөр” сонинд ярилцлага өгсөн.

Бүсийн сургалт семинар зохион байгуулах явцад орон нутгийн иргэд болон ойн мэргэжлийн байгууллагууд ойн магадлан итгэмжлэлийн талаар тодорхой ойлголт авах сонирхол их байсан нь ОМИ талаар илүү их мэдээ мэдээлэл хүргэх шаардлагатай байгааг харуулж байна. 2017 онд Сэлэнгэ аймгийн 7 ойн мэргэжлийн байгууллага итгэмжлэлд хамрагдлаа. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудад Төрөөс үзүүлэх урамшуулал, хөнгөлөлт тодорхой болбол ойн мэргэжлийн байгууллагууд итгэмжлэлд өргөнөөр хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Хэдийгээр ОМИ хэмээх ойлголт Монголд анхан шатандаа хөгжиж байгаа боловч бүсийн сургалт, итгэмжлэлийн үр дүнгээс үзэхэд ОМИ нь Монголын ойн салбарын хөгжилд чухал ач холбогдолтой арга хэмжээ болох нь харагдаж байна.

Гарчиг

Гүйцэтгэлийн Хураангуй	5
Товчилсон үгийн тайлал	1
1. Оршил	2
II. “Ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ (MSFM) зорилго.....	3
III. МОТМЗ ТББ-ын 2017 онд хийгдсэн ажилууд	3
Гүйцэтгэх ажил 1. “Магадлан итгэмжлэлийн үндэсний тогтолцоог бий болгох”	3
1. Үндэсний магадлан итгэмжлэлд зориулсан шинэ лого.	3
2. Ойн мэргэжлийн байгууллагуудыг итгэмжлэх нь	4
2.1. Итгэмжлэгдсэн байгууллагуудын ахиц дэвшлийн тайлан:	4
2.2. 2017 онд итгэмжлэгдсэн Ойн мэргэжлийн байлгууллага	6
3. Магадлан итгэмжлэлийн “шинжээч”-ийг бэлтгэх сургалт	11
4. Итгэмжлэлд хамрагдсан ОМБ уудад үзүүлэх урамшууллын талаар БОАЖЯ тай хэлэлцэх нь.....	12
Гүйцэтгэх ажил 2. “Ойн бүтээгдэхүүний магадлан итгэмжлэл”	13
Гүйцэтгэх ажил 3. Ойн тогтвортой менежмент, магадлан итгэмжлэлийн мэдээлэл сурталчилгаа”	13
3.1 МОТМЗ ын албан ёсны вэб хуудас	13
3.2 2017 онд зохион байгуулсан сургалт семинар.....	14
3.3 ОМИ-ийн талаарх богино хэмжээний кино.....	18
3.4 ОТМ ийг сурталчилах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх	19
Гүйцэтгэх ажил 4. ТББ-ын чадавхийг сайжруулна.....	21
4.1 МОТМЗ ТББийн төлөөлөл БНХАУ-д хийсэн уулзалт	21
4.2 МОТМЗ ТББ-ын Удирдах зөвлөлийн хурал	23
4.3 FCS болон PEFC –ийн үйл ажиллагааг харьцуулсан баримт бичгүүдийн судалгаа.....	25
IV. Дүгнэлт	27
Талархал.....	29
Хавсралт I Ажлын нөхцөл	30
Хавсралт II МОТМЗ ТББ танилцуулга	32
Хавсралт III: Ойн магадлан итгэмжлэлийн лого ашиглах журам	33
Хавсралт IV: Ойн магадлан итгэмжлэлийн шинжээчийн сургалтын хөтөлбөр.....	35
Хавсралт V: Сургалтанд тавигдсан илтгэлүүд.....	37
Хавсралт VI: ОМИ-д хамрагдсан ОМБ-т дэмжлэг үзүүлэх гэрээ	51
Хавсралт VII Байгаль орчны яамтай хамтрах ажиллах санал захидал.....	55
Хавсралт VIII: семинар зохион байгуулах тухай албан бичиг	56
Хавсралт IX: Маргаан шийдвэрлэх журам	57
Хавсралт X: СЕМИНАРЫН ХӨТӨЛБӨР.....	60
Хавсралт XI: Ахиц дэвшлийн тайлан.....	75

Товчилсон үгийн тайлал

ОМИ	Ойн магадлан итгэмжлэл
ОМБ	Ойн мэргэжлийн байгууллагууд
FSC	Forest Stewardship Council (Ойн эздийн холбоо)
ОН	Ойн нөхөрлөл
ОА	Ойн анги
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ОМИЗ	Ойн магадлан итгэмжлэлийн зөвлөл
ОМС	Ойн магадлан итгэмжлэлийн стандарт
МОТМЗ	Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
БоАХ	Бодлого, арга хэмжээ
PEFC	Program for the Endorsement of Forest Certification
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
REDD+	Reduced Emissions from Deforestation and Degradation
АД	Ажлын даалгавар
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
МҮИГ	Монголын Үндэсний Итгэмжлэлийн газар
МОСНХ	Монголын Ойн салбарын нэгдсэн холбоо ТББ
МОМУЭХ	Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо ТББ

1. Оршил

ГОУХАН-ээс хэрэгжүүлж байгаа “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II” хөтөлбөр, “Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ-ийн хооронд Үндэсний магадлан итгэмжлэлийн загварыг бий болгож хөгжүүлэх, Монголын ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх #83255181 тоот гэрээ байгуулав. (Хавсралт I. Ажлын даалгавар)

“Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II” хөтөлбөрийн зорилтууд нь:

- (1) Ногоон хөгжлийн бодлого, Ойн талаар баримтлах бодлогод нийцсэн эрх зүй, зохион байгуулалтын оновчтой шийдлийг бий болгох
- (2) Ойн тогтвортой менежментийн арга зүй, дүрэм журмыг төрийн болон аж ахуйн нэгжийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлэх
- (3) Ойн салбарын чадавхыг бүх түвшинд нэмэгдүүлэх зэрэг болно.

Эдгээр зорилтын хүрээнд Монгол улсад ойн магадлан итгэмжлэлийг нэвтрүүлэх, ойн тогтвортой менежмент, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг бий болгож хэрэгжүүлэх зорилгоор “МОТМЗ” ТББ тай хамтран ажиллаж байна.

ГОУХАН-ны санхүүжилтээр Хессен Форст олон улсын зөвлөх байгууллагаас 2013-2015 онуудад Үндэсний ойн магадлан итгэмжлэл, гэрчилгээжүүлэх ажилд аж ахуйн нэгж байгууллагуудад тавих стандарт, шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох, магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл байгуулах шаардлагын талаар судалгаа хийж, энэ талаар талуудыг оролцуулсан ярилцлага, семинар олон удаа зохион байгуулсан байна. Харин 2014 оны 11-р сард ойн магадлан итгэмжлэлийн анхны үндэсний семинарыг ойн холбогдох оролцогч талууд, БОНХЯ-ны төлөөлөл, Монголын ойн ТББ, ойн аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан.

Энэхүү семинарын үр дүнд санаачлагч 19 хүний хүсэлтээр Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ыг 2015 оны 3-р сарын 19-нд албан ёсоор байгуулж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр ойн магадлан итгэмжлэх байгууллага бий болсон юм.

“Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II” хөтөлбөр, “Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ-ийн хооронд байгуулсан гэрээт ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

Ажлын даалгавар 1: “Магадлан итгэмжлэлийн үндэсний тогтолцоог бий болгох”

- Үндэсний магадлан итгэмжлэлд ашиглах “лого” загварыг гаргаж, магадлан итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдэд ашиглах журмыг боловсруулж хэрэгжүүлнэ;
- Магадлан итгэмжлэгдсэн ААН-д олгох хөнгөлөлт, урамшууллын механизмийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна

- Магадлан итгэмжлэлийн “шинжээч” бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалт зохион байгуулан. Ур чадвартай шинжээчийн тоог нэмэгдүүлж зах зээлд өрсөлдөх нөхцлийг бүрдүүлнэ.

Ажлын даалгавар 2: “Бүтээгдэхүүний магадлан итгэмжлэл хийх боломжийг судална”

- Ойн бүтээгдэхүүний туршилтын магадлан итгэмжлэл хийнэ. Хусны нүүрс г.м
- Магадлан итгэмжлэгдсэн бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийн судалгаа хийнэ. Тухайлбал хусны нүүрсийг БНСУ-ын зах зээлд нийлүүлэх боломж гэх мэт
- Магадлан итгэмжлэлд хамрагдах боломжтой ойн бүтээгдэхүүний судалгаа хийнэ.

Ажлын даалгавар 3: “Ойн тогтвортой менежментийг сурталчилах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх”

- ТББ-ын цахим хуудас гаргаж, тогтмол мэдээлэл оруулна. Магадлан итгэмжлэлтэй холбоотой мэдээлэл, гарын авлага боловсруулж хэвлүүлнэ
- Ойн тогтвортой менежмент, магадлан итгэмжлэлийн талаар хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэл, ярилцлагууд гаргаж олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулна.
- Сонгосон 3 аймагт Магадлан итгэмжлэлийг сурталчлах, мэдээлэл өгөх, сургалт семинарыг зохион байгуулна.

Ажлын даалгавар 4: “ТББ-ын чадавхийг сайжруулна.”

- Байгууллагын үйл ажиллагааны явцад магадлан итгэмжлэлийн сан бүрдүүлж эхлэнэ;
- Магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх гэрээний төсөл боловсруулна.
- МОТМЗ ТББ-ийн төлөөлөл БНХАУ-ын туршлагыг судлах.

II. “Ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ (MSFM) зорилго

“Ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ, түүний ажлын алба нь ойн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх үндэсний механизмийг бий болгох, холбогдох дүрэм журам, шаардлага, шалгуур үзүүлэлтийг Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагын шаардлагатай нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

III. МОТМЗ ТББ-ын 2017 онд хийгдсэн ажилууд

Гүйцэтгэх ажил 1. “Магадлан итгэмжлэлийн үндэсний тогтолцоог бий болгох”

1.Үндэсний магадлан итгэмжлэлд зориулсан шинэ лого.

Зураач С.Санжаажамцтай гэрээ байгуулж, ТББ-ын үйл ажиллагаа, магадлан итгэмжлэлд ашиглах “лого”-ны загварыг гаргаж удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар баталгаажуулсан (Зураг 2-3, Хавсралт III). ТББ-ын болон Магадлан итгэмжлэлийн лого-

г Оюуны өмчийн газарт бүртгүүлж патент авах талаар “IP Consulting” ХХК-аар зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн.



Зураг 1. МОТМЗ ТББ-ын лого



Зураг 2. Бүтээгдэхүүний лого

2. Ойн мэргэжлийн байгууллагуудыг итгэмжлэх нь

2.1. Итгэмжлэгдсэн байгууллагуудын ахиц дэвшлийн тайлан:

Хангайн бүргэд ХХК нь “МОТМЗ” ТББ-аас Монгол улсад нэвтрүүлж эхэлсэн ойн магадлан итгэмжлэлийг дэмжин хүлээн авсан анхны байгууллагын нэг билээ. Магадлан итгэмжлэл нь бидний дотроо олж хараагүй, ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалахын зэрэгцээ үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд сайнаар нөлөөлсөн, байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлсэн ажил байлаа. Шинжээч нарын гаргасан зөвлөмж дүгнэлт нь оновчтой бөгөөд ойлгомжтой, заасан хугацаанд хэрэгжүүлэх боломжтой байв. Манай компани магадлан итгэмжлэлээр 100 оноо авахаас 78 оноо авч тэнцсэн боловч бид тэнцсэндээ тайвшралгүй оноогоо ахиулахын төлөө хичнээн ажиллаа.

(Хүснэгт1). Шинжээч нартай хамтран гаргасан Магадлан итгэмжлэлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

№	Чиглэл	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа
1	1.1	Гэрээт ажилчидтай хөдөлмөрийн гэрээтэй ажиллах	2017 оны 1 сараас 1 сар
		Мод бэлтгэх, тээвэрлэх, зүсмэл үйлдвэрлэх, зарим механик боловсруулалтын ажил дээр мэргэжлийн инженертэй болох	2017 оны 1 сараас 1 жил

2	2.1	Мод бэлтгэлд ашиглагдаж байгаа хөрөөг гэрчилгээжүүлэх	2017 оны 1 сараас 1ээс 2жил
		Зүсмэл материалыг стандарт хэмжээгээр эсгэх, дугуйт хөрөөт суурь машиныг мэргэжлийн байгууллагын туслалтайгаар заавартай болгож баталгаажуулах	2017 оны 1 сараас 1 жил
3	3.1	Рамын хөрөөг ажилд бэлтгэх ирлэх, солбих, тохиргоо хийх ажлыг нарийн дэс дараатай хийж хэвших	2017 оны 1 сараас 1 жил
		Гуалин зүсвэрийн P36 хөрөө рамын аюулгүй ажиллагааны хаалт хамгаалалт, дохиоллын системийг иж бүрэн ажиллуулах арга хэмжээ авах	2017 оны 1 сараас
4	6.1	Хөрөө рамын урд хойд тэргэнцэрий жолооны хүрд, хавчих хумс зэргийг засаж сэлбэсэн.	
		МБ ийн талбайн цэцэрлэгээг чанаржуулж, гишүү мөчрийн овоолгын хоорондын зайг холтгон овоолгын хэмжээг томруулах	
		Зүсмэл модны стандарт сайжруулах	
5	9.1	Чанартай стандарт хэмжээний зүсмэл материал гаргахын тулд рамын тэргэнцэрийн замыг хөдөлгөөнгүй тэгш шулуун байрлуулах	2017 оны 1 сараас 2 жил
		Ойжуулалт нөхөн сэргээлтийг чанаржуулж орон нутагтаа дасан зохицсон тарьцаар ойжуулах	
		Мэргэжлийн ойжуулалтын техникч сургаж авах	
		Үр бэлтгэдэг мэргэжлийн компанитай байнгын гэрээтэй ажиллаж, захиалгаар өөрийн мод бэлтгэлийн талбайн ургамлын тойргоос буюу тухайн орон нутгаас үр бэлтгүүлж ойжуулалт нөхөн сэргээлтэндээ ашиглах	2017 оны 1 сараас 3 жил

Магадлан итгэмжлэлийг нийт 10 багц шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд манай компани 5 шалгуур үзүүлэлт дээр оноогоо бүрэн авч чадаагүй бөгөөд энэ дагуу магадлан итгэмжлэлийн шинжээч нар хэрэгжүүлэх төлөвлөгөөг зөвлөмжийн хамт гаргасан. Бид өдөр тутмын ажил, санхүү боломжтойгоо уялдуулан дараах ажлуудыг хийв :

- Зүсвэрийн Р63 хөрөө рамын аюулгүй ажиллагааны хаалт хамгаалалтыг сайжруулах, дохиоллын системтэй болгов. Мөн тэргэнцэрийн хавчих хумсыг, жолооны хүрдийг засав
- Шинээр гуалин зүсвэрийн Тайга 15 хөрөө суурилуулж, тавцант зүсвэрийн хөрөөгөө сольсон
- Гэрээт ажилчидтай хөдөлмөрийн гэрээтэй ажиллах хэвшил болгож ажиллах мэргэжлийн туршлагатай ойн инженертэй болсон.
- Мод бэлтгэлийн талбайн цэвэрлэгээг чанаржуулах тал дээр ажиллаж нэлээд ахиц гарсан. Мандал сум дундын ойн ангитай хамтран тоног төхөөрөмжөө сайжруулан цэвэр эко ой болох зорилт тавин хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Ойн сангийн талбай дээрээ мод үржүүлгийн газар байгуулж хүлэмжтэй болсон. Модны үрийг тухайн орчноосоо буюу тухайлбал өөрийн ойн сангаас бэлтгэж эхлээд байна.

“Сэлэнгэ бугант” болон “Буян Од” ХХК-уудын ахиц дэвшлийн тайланг хавсаргав. Хавсралт XI.

2.2. 2017 онд итгэмжлэгдсэн Ойн мэргэжлийн байлгууллага

“МОНМЗ” ТББ нь 2017 онд Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр, Алтанбулаг сумдын нутаг дэвсгэрт (үйлдвэрлэлийн ашиглалт, ойн арчилгаа, цэвэрлэгээ) үйл ажиллагаа явуулдаг 7 мэргэжлийн аж ахуйн нэгжид магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу итгэмжлэл хийн дүгнэлт, зөвлөмж гаргав. Үүнд:

1. Хярааний Хонхор ХХК,
2. Шинэ бадрах ХХК,
3. Сор Хүдэр ХХК,
4. Ургамал дөрөө ХХК,
5. Хүдэр мөнгөлөг ХХК,
6. Хүдэр Тамир ХХК,
7. Бугант Нандин ХХК зэрэг ААН-үүд хамрагдав .

Магадлан итгэмжлэлийн зорилго:

- Ойд үйлдвэрлэлийн ашиглалт ба ойн арчилгаа цэвэрлэгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийх шалгуур үзүүлэлтээр дүгнэх
- Магадлан итгэмжлэлийн талаар орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулж ойлгуулах
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж зөвлөмж гаргах

Магадлан итгэмжлэлийг Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ-ын Удирдах зөвлөлийн 2016 оны 9 сарын12-ны өдрийн хуралдааны 6-р тогтоолоор баталсан арга зүй, БОНХ-ийн сайдын 2013 оны А-126 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал” болон дор дурьдсан арга зүйг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- Баримт бичгийн дүн шинжилгээ
- Урьдчилан бэлтгэсэн шинжээчийн ажлын хуудас
- Газар дээрх ажиглалт, тэмдэглэл
- Баримт, нотолгоо
- Асуулга, ярилцлага (зөвшилцсөнөөр)
- Технологийн харьцуулалт

Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүргийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааг холбогдох баримтаар нотлогдох байдлыг харгалзан тогтоов. Түүнчлэн шалгуур үзүүлэлтийг магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны онцлог байдалд тулгуурлан 10 багцад хуваасан болно. Үүнд:

1. Хүний нөөц, боловсон хүчин, удирдлагын менежмент
2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын баримт бичиг
3. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
4. Галын аюулгүй байдал
5. Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, техник технологи
6. Мод ашиглалт, бүтээгдэхүүн
7. Үйл ажиллагааны хамрах хүрээ
8. Орон нутгийн үнэлгээ
9. Мод бэлтгэсэн талбайн ойжуулалт, ойн нөхөн сэргээлт
10. Ойн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1: 2017онд Ойн магадлан итгэмжлэлд хамрагдсан ОМБ-ын жагсаалт

#	Өдөр	ОМБ нэрс	Газар зүйн байрлал	Холбоо барих
1	11.16	Хярааны хонхор ХХК	Сэлэнгэ, Алтан булаг	94117980
2	11.17	Шинэ бадрах ХХК	Сүхбаатар	
3	11.18-11.23	Сор хүдэр ХХК	Сэлэнгэ, Хүдэр	95945749
4		Ургамал дөрөө ХХК		94051326, 96051326
5		Хүдэр Мөнгөлөг ХХК		99111894 99100938
6		Хүдэртамир ХХК		99025757
7	11.24-11.25	Бугант Нандин ХХК	Сэлэнгэ, Бугант тосгон	99065280 93115280

Хүснэгт 2 Ойн магадлан итгэмжлэлийн үр дүнг харуулсан хүснэгт

Ойн мэргэжлийн байгууллагууд	Хүний нөөц, боловсон хүчин, удирдлагын менежмент	Хөдөлмөрийн аюулгүй байдлын баримт бичиг	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	Галын аюулгүй байдал	Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, техник, технологи	Мод ашиглалт, бүтээгдэхүүн	Үйл ажиллагааны хамрах хүрээ	Орон нутгийн үнэлгээ	Мод бэлтгэсэн талбайн ойжуулалт, ойн нөхөн сэргээлт	Ойн менежментийн төлөвлөгөө	Нийт
Авбал зохих оноо	17	21	18	6	9	13	6	3	4	3	100
Хярааны хонхор ХХК	11	19	8	4	0	8	6	3	4	2	65
Шинэ бадрах ХХК	8	14	11	3	2	12	4	3	4	3	64
Сор хүдэр ХХК	10	14	6	0	0	8	4	0	0	2	44
Ургамал дөрөө ХХК	12	16	12	3	0	10	4	3	0	2	62
Хүдэр Мөнгөлөг ХХК	14	15	13	5	4	12	4	3	4	3	77
Хүдэртамир ХХК	13	14	13	5	4	11	3	3	4	3	73
Бугант Нандин ХХК	16	21	12	6	2	12	4	3	4	2	82

Дэлгэрэнгүй тайлан хүргэгдсэн.


Ойн магадлан итгэмжлэлийн үйл явц

Ө.Болор ахлагчтай ойн магадлан итгэмжлэлийн багийн гишүүд шинжээчийн ёс зүйг чанд сахин, хараат бус, шударга, мэргэжлийн ур чадвар, туршлагад тулгуурлан асуудлыг бодитойгоор үнэлж, дүгнэнэ. Багийн гишүүд ярилцаад ойлголтоо нэгтгэн шийдвэрт хүрэх үүднээс шалгуур үзүүлэлт бүрдээр багаараа хамтран ажиллав. Огноо, цаг минут бүхий аппаратаар баримт нотолгоо, ажлын явцын онцгой агшинг зурагжуулах ажлыг багийн гишүүн Л.Энхбат хариуцан хийж, машин механизмын техникийн үзүүлэлт, ХАБ-ын талаар багийн гишүүн У.Ганбат хариуцан магадлан итгэмжлэлийг хийх бол багийн ахлагч магадлан итгэмжлэлийн чиглэл бүр дээр хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтийг нягтлан үзэж бичиж тэмдэглэх ажлыг хийж гүйцэтгэв. Мэдээлэл болон асуулгыг зөвхөн ахлах шинжээчээр дамжуулан авна. Багийн гишүүд нь өөрийн мэргэжлийн дагуу асуудлыг үнэлэх, дүгнэх арга зүйг эзэмшсэн байх бөгөөд багийн гишүүд харилцан мэдээллээ хуваалцдаг байх. Магадлан итгэмжлэлийн ажлын явцад Ахлах шинжээч нь аль нэг гишүүнийг төлөөлөх эрхтэйгээр оролцоно.

ОМИ-д хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ерөнхий төлөв

Мод бэлтгэх, боловсруулах, үйлдвэрийн тоног төхөөрөмж тус бүр дээр хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан баталж ажилладаг. Ажилд гарахын өмнө өдөр бүр зааварчилгаатай танилцсан тухай ажилчид гарын үсгээрээ баталгаажуулсан байна. Тоног төхөөрөмжийн хувьд ХАБ-ын шаардлагыг хангасан гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Ойн түймрээс урьдчилан сэргийлэх самбарыг талбайд байрлуулж, мод бэлтгэлийн талбайг цэвэрлэдэг. Үйлдвэрийн талбайд элс, галын хор зэргийг сараанд байрлуулсан. Ойн түймрийн үед хэрэглэх хүрз, резинен цохиур, тросон шүүр олонтой. ОБГ-аас жил бүр зохион байгуулдаг сургалтанд ажилчдаа идэвхтэй оролцуулдаг болохыг сургалтанд суусан гэрэл зураг нотолж байна. Асуулга ярилцлагын үед ахуйн хог хаягдлыг нэгдсэн цэгт авчирдаг, ажилчдын хувцас угаах түмпэн саваар хангадаг гэх боловч бичгэн заавар байсангүй. Тус компани нь сум орон нутгаас зохиогдсон аливаа ажилд идэвхтэй орлцдог иргэд олон нийтийн дунд нэр хүнд сайтай компани тул орон нутгийн үнэлгээ сайн байна. Ойжуулалтыг шаардлагын дагуу хийж актаар хүлээлгэж өгдөг. Ойжуулсан талбайд үзлэг хийхэд актан дээр бичигдсэн амьдралтын хувьдаа хүрэхгүй байдал ажиглагдсаныг цаашид анхаарах хэрэгтэй. Ойжуулалтын ажлыг хүлээн авсан актыг баримталсан тул оноогоо бүрэн авсан. Ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэж мөрдөн ажилладаг байна.

Зураг 3. Ажлын үйл явц



Магадлан итгэмжлэлийн хязгаарлалт:

Итгэмжлэлийн ажлыг дараах хязгаарлалтын хүрээнд хийхээр захиалагч байгууллагатай тохиров. Хууль эрх зүйн хүрээнд: Зөвхөн монгол улсад мөрдөгдөж байгаа дээр жагсаасан 15 хууль тогтоомжийн хүрээнд хийнэ (Хүснэгт 4). Орон зайн хувьд: Мод бэлтгэх боловсруулах, ойжуулах талбайд үйл ажиллагаа явуулсан байдалтай танилцсан. Цаг хугацааны хувьд: Магадлан итгэмжлэлийн ажлыг 2017 оны 10 дугаар сарын 16-аас 26- ыг дуустал хугацаанд дуусгана. Нөхцөл байдлын хувьд: Ой нээлтэй байсан ч зарим ААН-үүд мод бэлтгэлийн ажлаа эхлээгүй байна. Энэ нь 2 үндсэн шалтгаантай.

- Сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийг сонгох сонгуулын үе

- Самар жимс боловсорч түүх үе

Мод бэлтгэлийн бригад ажиллаж байх үед үзэх боломжтой гадаргын усыг бохирдуулахгүй байх арга хэмжээ авсан байдал, хөрсөн дээр санамсаргүй асгасан тосыг цэвэрлэсэн байдал зэргийг газар дээр нь үзэх боломжгүй.

Доод склад дээр гуалин, түлээ дууссан тул бөөрөнхий ба модон материалын стандартын хэрэгжилтийг үзэх боломжгүй

Хүснэгт 3: Ашигласанбаримтбичгийнжагсаалт

No	Нэр
1	“Байгаль орчныг хамгаалах тухай” монгол улсын хууль 1995 он
2	“Ойн тухай “ монгол улсын хууль 2012он /Шинэчилсэн найруулга/
3	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” 2012 он /Шинэчилсэн найруулга/
4	“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль” 2012 он, /Шинэчилсэн найруулга/
5	“Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал” Улаанбаатар хот 2010 он
6	“Аж ахуйн нэгж байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам” Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолын хавсралт
7	“Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам” БОНХ Сайдын 2013 оны 8 сарын 7-ны өдрийн А-223 дугаар тушаалын хавсрал
8	“Ойн санг гэрээгээр эзэмших журам” Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолын хавсралт
9	“Байгаль орчны аудит хийх журам” БОНХСайдын 2013 оны 4 сарын 24-ний өдрийн А-126 дугаар тушаалын 1-р хавсрал
10	“Ойд арчилгаа цэвэрлэгээ хийх журам” БОНХСайдын 2013 оны 9 сарын 2-ний өдрийн А-244 дугаар тушаалын хавсралт
11	“Ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар” Ойн газрын даргын 2009 оны 6 сарын 24-ний өдрийн 70 тоот тушаалын 1 дүгээр хавсралт
12	“Ойд үйлдвэрлэлийн ашиглалт” ба “Ойн арчилгаа цэвэрлэгээний үйл ажиллагаа эрхэлдэг ААН, байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийх шалгуур үзүүлэлтийг дүгнэх аргачлал, МОТМЗ ТББ-ын Удирдах зөвлөлийн 6 дугаар тогтоол
13	Шилмүүст төрлийн бөөрөнхий модон материал MNS 6142 : 2010
14	Шилмүүст төрлийн зүсмэл материал MNS 0391: 201
15	Бөөрөнхий модон материал. Эзэлхүүний хүрд MNS 6142 : 2010

3. Магадлан итгэмжлэлийн “шинжээч”-ийг бэлтгэх сургалт

Олон улсын стандартын академи ХХК болон ЭРИН ҮЕ-ЭКОЛОГИ ХӨГЖИЛ ТББ-тай (MonCert LLC) хамтран магадлан итгэмжлэлийн “Шинжээч” бэлтгэх сургалтыг 2017 оны 9 сарын 11-12 нд хамтран зохион байгуулсан. Нийтдээ 12 мэргэжилтэн сургалтад хамрагдаж шинжээчийн үнэмлэх батламжаа гардан авсан. Сургалтын ерөнхий агуулга нь “шинжээч”-ийн ёс зүй, хараат бус байдал, мэргэжлийн ур чадвар, нотлох баримтыг бүрдүүлэх, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг үнэлэх арга зүй зэрэг шаардлагатай асуудлыг хамарсан (Хавсралт V) Хүснэгт 5.

Илтгэлийн сэдэв	Агуулга	Илтгэгч
Олон улсын болон Монгол улсын Магадлан итгэмжлэлийн тогтолцоо	ОМИ ийн хөгжил ОУын байгууллагуудын танилцуулга, Монгол орны ОМИ ийн өнөөгийн байдал	Д.Мөнхзориг (МОТМЗ гүйцэтгэх захирал) О.Билгүүтэй (Менежер)
Магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчны төсөл (ойн тухай хууль, журам)	ОМИ ийн хууль эрх зүйн орчин, хөнгөлөлт урамшуулалтын санал	Л.Доржцэдэн МОТМЗ тэргүүн
Аудитын төрлүүд, /19011,17021 стандартын талаар/	Олон улсын стандарт	Тунгалаг (Олон улсын шинжээч, багш)
Мод бэлтгэлийн аюулгүй ажиллагаа Мод Цагаалга	ХАБ болон мод бэлтгэлийн ажлын аргачлал	Ганбат (Профессор)
Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүд, түүнийг үнэлэх нь	<ul style="list-style-type: none">ОМИ шалгуур үзүүлэлтОМИ зорилгоҮнэлгээний арга зүй	Ө.Болор (Ахлах шинжээч)



Зураг 4 Сургалтад оролцогчид



Зураг 5 Багаар ажиллаж буй оролцогчид

Ойн магадлан итгэмжлэлийн шинжээчид тавигдах шаардлагууд:

1. Ойн мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх
2. Ойн салбарт 5-аас дээш жил ажилласан, ойг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх талаархи ажлын туршлагатай байх;
3. Төрийн бус байгууллага болон төрийн захиргаа, олон улсын байгууллагад ойн чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан байх шаардлагай.

Түүний зэрэгцээ дараахи чиглэлийн судалгаа, мэдээлэл, мэдлэгтэй байвал зохино.

Үүнд:

- Монголын ойн салбарын түүхэн замнал, салбарын бүтэц зохион байгуулалт, ойн алба, ойн анги, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудын талаар судалгаа, мэдээлэлтэй байх;
- Байгаль орчны болон Ойн тухай хууль тогтоомжийн өргөн хүрээний мэдлэгтэй байх;
- Ойн тогтвортой менежментийн тухай болон Ойн менежментийн төлөвлөгөө, ойн аж ахуйн арга хэмжээний мэдлэг, туршлагай байх;
- Ойг хамгаалах арга хэмжээ, ус, хөрсийг хамгаалах, ойн ашиглалтын үеийн эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар өндөр мэдлэг, туршлагатай байх.

4. Итгэмжлэлд хамрагдсан ОМБ уудад үзүүлэх урамшууллын талаар БОАЖЯ тай хэлэлцэх нь

- ГОУХАН-ны Зөвлөх Ц.Банзрагчтай хамтран Ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсрууллаа. Журмын төсөлд мэргэжлийн байгууллагын эрх авахад магадлан итгэмжлэл заавал хийлгэх тухай

заалт болон магадлан итгэмжлэлийг бие даасан ТББ гүйцэтгэхээр заалт оруулж магадлан итгэмжлэл хийх ТББ-д байгуулагад тавигдах шаардлагыг тодорхойлж оруулсан.

- БОАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Тунгалагтай 9 сарын 5-нд уулзаж ТББ-ын үйл ажиллагаа, магадлан итгэмжлэлийн тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл өгч санал солилцсон. Уулзалтын үр дүнд БОАЖЯ-наас ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж байгаагаа уламжилсан “албан бичиг” гаргаж “Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлж, нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих нь” төсөлд хүргүүлсэн. Хавсралт VII
- 12-р сарын 6-ны өдөр зохион байгуулсан сургалтын үеэр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөөлөгч Н.Энхтайван (Ойн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн) шинэ хуулийн төслийг танилцуулсан ба энэ нь ойн мэргэжлийн байгууллагын эрх авахын өмнө ОМИ хамрагдах шаардлагатай гэсэн шинэ заалт юм.

Гүйцэтгэх ажил 2. “Ойн бүтээгдэхүүний магадлан итгэмжлэл”

МОТМЗ ойгоос гаралтай бүтээгдэхүүний итгэмжлэлийг хэрэгжүүлэх, туршилтын бүтээгдэхүүн итгэмжлэх зорилттой байсан авч дараах шалтаануудын улмаас энэ удаагийн тайланд тусгагдаагүй болно. Үүнд:


- Олон улсын бүтээгдэхүүн итгэмжлэлийн үйл явц эхлээд ойн менежмент дээр дараа бүтээгдэхүүн дээр итгэмжлэл явуулдаг бол Монголд Ойд үйл ажиллагаа эрхэлж буй ОМБ дээр хийдэг.
- Анх төлөвлөгөөнд Бүтээгдэхүүний итгэмжлэлтэй холбоотой судалгаа, үйл ажиллагааг Сонечсен консалтин ХХК-тай хамтран ажиллахаар төлөвлөсөн боловч тус компаний зөвлөх үйлчилгээний гэрээ хийгдээгүй.

Гүйцэтгэх ажил 3. Ойн тогтвортой менежмент, магадлан итгэмжлэлийн мэдээлэл сурталчилгаа”

3.1 МОТМЗ ын албан ёсны вэб хуудас

ТББ-ын үйл ажиллагаа, магадлан итгэмжлэлийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх www.forest.mn домайн нэрийг ТББ-ын нэр дээр баталгаажуулан авсан. Вэб сайт хийлгэх гэрээг “Грийнсофт” ХХК-тай байгуулан холбогдох материалыг бэлтгэсэн. Вэб сайт 7 сарын 1-нээс ажиллаж эхлэсэн.

Зураг 6. МОТМЗ ын албан ёсны вэб хуудас



3.2 2017 онд зохион байгуулсан сургалт семинар.

Магадлан итгэмжлэлийн бүсийн семинарыг Булган, Хэнтий аймагт хийхээр шийдвэрлэж тухайн аймгуудын БОАЖГ-тай ярилцаж, хамтран сургалт семинар зохион байгуулах тухай албан бичгийг хүргүүллээ.

- Сэлэнгэ аймаг 71 хүн оролцов (5 сарын 25 нд)
- Булган аймаг 52 хүн оролцов (9 сарын 6 нд)
- Хэнтий аймаг 34 хүн оролцов (10 сарын 6 нд)

Бүсийн семинарт оролцогчид БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, ойн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөгчид оролцсон. Семинар дээр дараах сэдвүүдээр илтгэл тавив:

- Олон улсын болон Монгол улсын Магадлан итгэмжлэлийн тогтолцоо
- Магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчны төсөл (ойн тухай хууль, журам)
- Магадлан итгэмжлэлийн үнэлгээ шалгуур үзүүлэлт, арга зүй

СЭЛЭНГЭ АЙМАГТ “ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЧАДВАРЖУУЛАХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН

Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын жилийн ажлын төлөвлөгөөнд “Магадлан итгэмжлэлийн чиглэлээр 3 аймагт сургалт, семинар зохион байгуулна” гэж тусгагдсаны дагуу 5 дугаар сарын 25-нд Сэлэнгэ аймагт “Ойн мэргэжлийн байгууллагуудыг чадваржуулах нь” сэдэвт сургалт семинарыг Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нь” II хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хөтөлбөрийн

дагуу хамтран зохион байгуулав. Уг сургалт семинарт нийт 71 хүн оролцсоны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газар, зарим Сумын засаг дарга, сумдын Сум дундын Ойн ангийн удирдлага, инженер 20, Сэлэнгэ аймгийн 13 сумын ойн мэргэжлийн 51 байгууллагын удирдлагууд оролцлоо.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцогтой уулзаж, сургалт семинарын зорилго, ойн магадлан итгэмжлэл, магадлан итгэмжлэлд хамрагдсан ойн мэргэжлийн байгууллагуудад үзүүлэх хөнгөлөлт урамшууллын тухай танилцуулав. Энэ уулзалтанд Ерөө сумын Засаг дарга М.Ганбаатар, Ерөө бүсийн Сум дундын Ойн ангийн дарга С.Бат-Амгалан нарыг оролцуулав. Тэрээр ойн магадлан итгэмжлэлийн сургалт семинар нь ойн мэргэжлийн байгууллагуудыг чадваржуулах, ойн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэдгийг тэмдэглээд Аймаг, сумын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөлийн “Магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх гэрээ”-ний төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн болно.

Сургалт семинар батлагдсан хөтөлбөрийн дагуу явагдаж, хурлын үйл ажиллагааг Сэлэнгэ аймгийн Миний монгол телевиз, TV 9 ээр сурталчилж, ойн магадлан итгэмжлэл, түүний эрх зүйн орчин, магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагуудад орон нутгийн төрийн байгууллагаас дэмжлэг үзүүлэх талаар ярилцлага өгөв. Мөн түүнчлэн аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, МОТМЗТББ-ын удирдлага Л.Доржцэдэн, Д.Мөнхзориг нар 2016 онд магадлан итгэмжлэгдсэн Сэлэнгэ Бугант ХХК-ны захирал Л.Гандөш, Буян-Од ХХК-ны захирал В.Буянтогтох, Хангайн бүргэд ХХК-ны захирал Л.Тлейберд, УВЦО ХХК-ны захирал Ц.Баасансүрэн нарт ойн магадлан итгэмжлэлийн гэрчилгээг гардуулав..

Сургалт семинарт оролцогчид сургалт семинарын явцад ойн магадлан итгэмжлэлийн тухай зохих хэмжээний ойлголттой болсон тухай санал бодлоо хэлж, ойн магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлтээ илэрхийлж байлаа. Сургалт семинарын явцад оролцогчдоос зарим асуулт гарч, дор бүр нь дэлгэрэнгүй хариуг өгөв.Тухайлбал Хүдэр сумын Хүдэртэйн буян ХХК-ны захирал Пүрэврэнцэн ойн магадлан итгэмжлэлийн орон нутгийн эрслийн, Мандал сумын Мортир ХХК-ны захирал Т.Дорж ойн магадлан итгэмжлэлийн төлбөрийн талаар асууж тодруулав. МОТМЗТББ-ын удирдлага Л.Доржцэдэн, Д.Мөнхзориг нар эдгээр асуултанд дэлгэрэнгүй хариу өгөв.

“Магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх гэрээ”-ний төслийг , сургалт семинарт ойн магадлан итгэмжлэлийн талаар тавигдсан илтгэлүүдийг /Ойн магадлан итгэмжлэл, шалгуур үзүүлэлтийн тухай, Ойн магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчин, урамшуулал бий болгох тухай, Ойн мэргэжлийн байгууллагуудад магадлан итгэмжлэл явуулсан ажлын үр дүн, санал, зөвлөмж, Ойн

магадлан итгэмжлэлд хамрагдсан ойн мэргэжлийн зарим байгууллагын туршлага, санал, зөвлөмж/ тус тус хавсаргав.

Зураг 7. Сэлэнгэ аймагт зохиогдсон сургалтад оролцогсод



ХЭНТИЙ АЙМАГ БИНДЭР СУМ “МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЧАДВАРЖУУЛАХАД ОЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ” СЭДЭВТ СУРГАЛТ

Сургалт семинарыг Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Биндэр ой” СДОА, Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ хамтран Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нь” II хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулав. Семинарыг 10 сарын 06 өдөр зохион байгуулж уг семинарт Хэнтий аймгийн Биндэр сумын БОАЖГ-ын дарга төлөөлөгчид, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар, ойн мэргэжлийн байгууллагууд, нийт 34 хүн оролцов

Зураг 8. Хэнтий аймагт зохиогдсон сургалтад оролцогсод



Булган аймаг "Ойн мэргэжлийн байгууллагуудыг чадваржуулахад ойн магадлан итгэмжлэлийн үзүүлэх нөлөө" сургалт семинар

БОАЖЯ, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдал ба ойн гол экосистемүүд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн БОАЖГ-тай хамтран “Ойн мэргэжлийн байгууллагуудыг чадваржуулахад ойн магадлан итгэмжлэлийн нөлөө” сургалт семинарыг 9 сарын 29 өдөр зохион байгуулж уг семинарт Булган аймгийн БОАЖГ-ын дарга төлөөлөгчид, Онцгой байдлын алба, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар, ойн мэргэжлийн байгууллагын 27 байгууллага нийт 52 хүн оролцов.

Зураг 9. Хэнтий аймагт зохиогдсон сургалтад оролцогсад



“ОЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ҮНДЭСНИЙ СЕМИНАР

Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нь” II хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Үндэсний семинарыг 2017 оны 12-р сарын 6-ны өдрийн 09:00–17:00 цагт “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн хурлын танхимд зохион байгуулав. Семинарын үед тавигдсан илтгэлүүд:

- Д.Мөнхзориг.ТББ-ын гүйцэтгэх захирал: Ойн салбарт магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх талаар хийж гүйцэтгэсэн ажлын ололт, дутагдал, цаашдын зорилтын тухай
- М. Сэргэлэн ГОУХАН: Ойн магадлан итгэмжлэлийг Монгол улсад нэвтрүүлэхэд тулгарч буй асуудлууд
- Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл Б. Алтанчимэг: Монгол улсын боловсролын магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчин, тогтолцоо, шалгуур үзүүлэлт
- Л.Доржцэдэн ТББ-ын тэргүүн: Ойн магадлан итгэмжлэлийн оролцогч талууд, тэдгээрийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээний тухай

Семинар амжилттай зохион байгуулагдаж өндөрлөсөн ба оролцогчид идэвхитэй асуулт хариултад оролцож ойн итгэмжлэлийн талаар нээлттэй ярилцан, санал зөвлгөө, шүүмжтэй талуудыг хэлэлцсэн.(Хавсралт Х: Хөтөлбөр болон илтгэлүүд).

Зураг 10. Улаанбаатар хотод зохиогдсон сургалтад оролцогчид



3.3 ОМИ-ийн талаарх богино хэмжээний кино

"Танайд мод таръя" ТББ-тай хамтран ОМИ ажлын талаар богино хэмжээний кино болон нэвтрүүлэг бэлтгэн 2017 оны 12-р сар, 2018 оны 1-р сард ТВ9 сувгаар цацагдаж нийтийн хүртээл болов.

“ОЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ” БОГИНО ХЭМЖЭЭНИЙ КИНОНЫ СЦЕНАРИ

1. Ойн магадлан итгэмжлэлийн тухай

- Ойн тогтвортой менежмент
- Олон улсын ойн магадлан итгэмжлэлийн байгууллагууд
- Магадлан итгэмжлэлийн тогтолцоо /Стандарт тогтоох, баталгаажуулах, итгэмжлэх/

2. Магадлан итгэмжлэлд хамрагдсаны ач холбогдол, үр ашиг

- Байгаль орчны үр ашиг
- Эдийн засгийн үр ашиг
- Нийгмийн үр ашиг

3. Магадлан итгэмжлэлийн стандарт, шаардлага, шалгуур, лого ашиглалт

- Үндэсний ойн магадлан итгэмжлэлийн шаардлага, шалгуур үзүүлэлт
- Мод модон бүтээгдэхүүний лого ашиглалт
- Ойн магадлан итгэмжлэлд хамрагдсан ойн мэргэжлийн байгууллагууд

4. Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ, түүний зорилго, үйл ажиллагааны чиглэл /Л.Доржцэдэн 2 мин/


- Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын үүсэл, хөгжил
- Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын зорилго
- Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын үйл ажиллагааны чиглэл

Үзэх холбоос: <https://www.youtube.com/watch?v=PAdQKxJHGVo&feature=youtu.be>

3.4 ОТМ ийг сурталчилах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

PR материал: БОАЖЯ-аас зохион байгуулсан "Нээлттэй өдөр" хөтөлбөрт 2017 оны 6-р сарын 5-нд оролцон МОТМЗ ТББ-аас ОМИ талаар танилцуулга хуудас тараав. Түүнчлэн 12-р сарын 6-ны өдөр ОМИ-ийн чадавхыг бэхжүүлэх семинар дээр 300 гаруй товхимолыг тараав. 2017 оны туршид нийт 600 гаруй танилцуулах хуудас, гарын авлага ном хэвлүүлэн сургалт семинарын үер тараагдсан.

Зураг 11. ОМИ талаарх танилцуулга хуудас





Олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд Өнөөдөр сонинд ярилцлага өгөв:

Бидний төлөвлөсний дагуу МОТМЗ-ийн гүйцэтгэх захирал М.Мөнхзориг Монголын өдөр тутмын сонин "Өнөөдөр" сонинд ярилцлага өгөв. Ноён Мөнхзориг Монгол орны ойд хийсэн магадлан итгэмжлэлийн туршлага, асуудал, ашигтай талууд болон сүүлийн үеийн нөхцөл байдлын талаар ярилцлаа. Та доорх холбоосоор бүрэн ярилцлагыг үзэж болно

Үзэх холбоос:

http://unuudur.mn/article/101032?utm_campaign=playbuzz&pb_traffic_source=facebook&utm_source=facebook

Зураг 12. Өнөөдөр сонины ярилцлагын хэсэг





Гүйцэтгэх ажил 4. ТББ-ын чадавхийг сайжруулна.

4.1 МОТМЗ ТББийн төлөөлөл БНХАУ-д хийсэн уулзалт

МОТМЗ ТББ нь БНХАУ-ын “PEFC санаачилга” байгууллагатай 2016 оноос хойш ажил хэргийн харилцаатай байсан. БНХАУ-ын “PEFC санаачилга” байгууллагаас 12-р сарын 20-24-ны өдрүүдэд Хятад улсад айлчилах урилга ирүүлсэн. Энэхүү урилгыг үндэслэн Д.Мөнхзориг, Л.Доржцэдэн нар 2017 оны 12-р сарын 19-25-ны өдрүүдэд БНХАУ-д ажилласан. Энэхүү аялалын гол зорилго нь Хятадын ойн магадлан итгэмжлэлийн үйл явцтай танилцах, Хятадын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн удирдлагатай уулзаж мэдээлэл солилцох, ОМИ -тэй холбоотой асуудын талаар ярилцах явдал байсан. Хятад дахь PEFC салбар нэгж айлчлалын бүх хөтөлбөр уулзалтуудыг зохион байгуулсан болно.

Хятад дахь PEFC салбар: нь Хятад улсын хууль журмын дагуу албан ёсны бүртгэгдсэн байдаг ба Австралийн Женев дэх PEFC-ийн төвийн шууд удирдлагад ажилладаг байна. Хятад дахь PEFC байгууллагын гол зорилго нь CFCC (Хятадын магадлан итгэмжлэлийн зөвлөл) болон SFA (Ойн улсын алба)-г дэмжиж, хамтран ажиллах явдал юм.

Зураг 13: Хятадад болсон уулзалтад оролцогсод



CFCC (Хятадын магадлан итгэжлэлийн үндэсний зөвлөл): Энэ нь Хятад дахь ОМИ ийн гол байгууллага ба CFCC нь 25 гишүүнтэй бөгөөд ерөнхий захирал Ван Вэй гэх эрхэм байна.

Хятад дахь хуралд оролцогчийн жагсаалт

1. Ноён. Ван Вэй Хятадын магадлан итгэжлэлийн үндэсний зөвлөл- ийн дарга
2. Хатагтай Юн Линг Хятадын магадлан итгэжлэлийн үндэсний зөвлөл- ийн ерөнхий нарийн бичиг
3. Ноён Жао Jie Хятадын Ойн академи (Стандарт хөгжлийн дарга)
4. Ноён.Зен Ойн улсын албаны олон улсын хамтын ажиллагааны төв
5. Ноён.Бенсон Хятад дахь PEFC салбарын захирал /
6. Ноён Симон Мэн тус салбарын ажилтан

Уулзалт ярилцлагын хураангуй.

ОМИ -ийн санаачлалыг 2001 оноос эхлэн хэрэгжүүлж, ОМИ-тэй холбоотой бүхий л үйл ажиллагаа нь БНХАУ-ын Коммунист намын засгийн газар болон төрийн зөвлөлөөс хүчтэй дэмжлэг үзүүлсэн байна. Хятадын ОМИ удирдлага нь Үндэсний ойн албатай хамтран ажиллаж нэг салбарт хамрагддаг байна.

Хятадын ОМИ нь үндсэн 4 төрөлтэй байна. Үүнд:

1. Ойн менежмент
2. Бүтээгдэхүүний итгэмжлэл
3. Хулс
4. Нүүрстөрөгчийг шингээлт буюу экосистемийн үйлчилгээ

Үндэсний ОМИ ийн нийт 25 стандарт шалгуур үзүүлэлт байдаг ба үүнээс 23 нь ойн стандарт, 2 нь нийтлэг стандарт байдаг. 2009 онд Бээжинд ОМИ-ийн анхны байгууллага ("Zhonglin Tianhe (Beijing)") байгуулагдсан ба уг байгууллага нь Хятадын үндэсний итгэмжлэлийн байгууллагатай (CNAS) хамтран ажилладаг байна.

Хятадын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл нь ОМИ -ийн гол төлөөлөл болох FCS болон PEFC хоёртой хамтран ажилладаг ба БНХАУ-ын анхны ОМИ санаачлагыг WWF төслийн хүрээнд гаргаж байсан байна. Эцэст нь Хятадын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл нь дараахи шалтгаанаар PEFC-тэй хамтран ажиллахаар сонгосон байна.

1. FSC нь Үндэсний стандартыг хянаж батлах тодорхой механизм байхгүй
2. FSC нь тухайн улсын стандартыг хүлээн зөвшөөрдөггүй
3. PEFC нь үндэсний стандарт, лого ашиглахыг хүлээн зөвшөөрдөг
4. БНХАУ-ын төрийн бодлого FSC -н стандартыг хүлээн зөвшөөрөх боломжгүй
5. PEFC нь Үндэсний стандартыг хүлээн зөвшөөрөх тодорхой батлагдсан системтэй

Монгол Хятадын засгийн газрын бүтцийг хувьд харьцуулан үзвэл төрийн байгууллагуудын төвшинд маш ойролцоо байгаа юм. Энэ нь PEFC-ийг Монголд нэвтрүүлэхэд илүү тохиромжтой байж болзошгүй юм. Мөн Хятад дахь ОМИ-ийн салбарт ажилладаг мэргэжилтнүүд PEFC-нь Азийн аль ч улсад тохиромжтой гэдгийг санал болгож байлаа.

4.2 МОТМЗ ТББ-ын Удирдах зөвлөлийн хурал

МОТМЗ ТББ-ын Удирдах зөвлөлийн хурал 2017 оны 8 дугаар сарын 24 нд хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

- Ойн магадлан итгэмжлэлийн лого ашиглах түр журмын төсөл (Хавсралт III);
- Ойн магадлан итгэмжлэлийн Үндэсний зөвлөлийн Маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмын төсөл (Хавсралт IX);

- Магадлан итгэмжлэгдсэн ойн мэргэжлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх гэрээний төсөл
- “Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл” ТББ-ын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд зарим өөрчлөлт оруулах тухай.

4.3 ОЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ойн магадлан итгэмжлэлийн тухай ойлголт, магадлан итгэмжлэлийн үйл явц, магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл, хамрагдах шаардлага, эрх зүйн орчин болон дараах сэдвүүд хамрагдав.

- Ойн магадлан итгэмжлэлийн тухай ойлголт, олон улсын байгууллагууд.
- Манай улсад ойн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэх ажлын явц.
- Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ, түүний үйл ажиллагаа.
- Ойн магадлан итгэмжлэлийг хэрэгжүүлэхэд учрах бэрхшээл сул тал болон давуу тал боломж, эрсдлийн үнэлгээ
- Магадлан итгэмжлэлийн оролцогч талууд, тэдгээрийн үүрэг хариуцлага, хэрэгжилт.
- Магадлан итгэмжлэлийн өнөөгийн үйл ажиллагаанд хийх дүгнэлт. зөвлөмж.

ОЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нэг.Ойн магадлан итгэмжлэлийн тухай ойлголт, магадлан итгэмжлэлийн үйл явц, магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл, хамрагдах шаардлага

